


"Багануур үйлдвэрлэл, технологийн парк"  
ОНӨТҮГ-ын даргын 2023 оны 06 дугаар сарын 19-ний  
едрийн А/08 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



## **"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛД АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Хуульд өөрөөр заагаагүй бол тус байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалд ажилтныг сонгон шалгаруулахдаа энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Тус сонгон шалгаруулалтад байгууллагын удирдлагаас бусад бүтэц орон тоогоор батлагдсан албан тушаалын сул ажлын байрыг хамааруулан ойлгоно.
- 1.3. Сонгон шалгаруулалт зарлагдах албан тушаал (ажлын байрны тодорхойлолтод заасан)-ын шаардлагыг хангасан, ажилтныг сонгон шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.

### **Хоёр. Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага**

- 2.1. Дээд боловсролтой
- 2.2. Ял шийтгүүлж байгаагүй
- 2.3. Сахилгын шийтгэлээр төрийн албанаас халагдаж байгаагүй
- 2.4. Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангасан байх;

### **Гурав. Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх**

- 3.1. Сонгон шалгаруулалтын зарыг 15-аас доошгүй хоногийн өмнө байгууллагын сайт болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан мэдээлэх ба бүртгэх хугацаа, байршил, холбогдох утас сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг зэргийг тусгасан зар байна.
- 3.2. Бүртгэл явуулах байр, хугацааг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай мэдээллийг мөн нээлттэй зарлана.
- 3.3. Сонгон шалгаруулалтын хугацаанд бүртгэл хийгдээгүй болон оролцогч шаардлага хангаагүй тохиолдолд дахин сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлнэ.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалт явуулах**

- 4.1. Оролцогчийн мэргэжил, мэдлэг, боловсрол, мэргэшил, туршлага, ур чадварыг үнэлэх замаар шалгаруулна.
- 4.2. Сонгон шалгаруулалтын үнэлгээгээр оролцогчдын мэдлэг, боловсролын түвшинд 30 хүртэл оноо, төрийн албаны мэргэшил, туршлагад 40 хүртэл оноо, мэргэжил, ур чадварт 30 хүртэл оноо, ярилцлагад 20 хүртэл оноо өгч нийт онооны нийлбэрийн дарааллаар жагсаалт гаргана.
- 4.3. Мэдлэг, боловсролын түвшинг үнэлэхдээ доорх хүснэгтэд үзүүлсэн оноог өгнө.

Боловсролын зэрэг	бакалавр	магистр	доктор
оноо	10	20	30

4.4. Мэдлэг, боловсролыг үнэлэхдээ оролцогчийн хамгийн дээд түвшинд харгалзах оноог өгнө.

4.5. Төрийн албаны мэргэшил, туршлагын үнэлгээг өгөхдөө өмнөх ажлын туршлага, ажилласан хугацаа болон төрийн албанд ажиллаж байсан бол ажилласан хугацаа зэргээр харгалзах оноог өгнө.

Ажилласан байдал	Ажиллаж байгаагүй, ажиллах эрмэлзэл	Өөр салбарт ажиллаж байсан		Төрийн албанд ажиллаж байсан	
		1-3 жил	3-аас дээш жил	1-3 жил	3-аас дээш жил
Ажилласан хугацаа	0				
оноо	5-10	15-20	21-25	26-30	35-40


4.6. Мэргэжил, ур чадварт үнэлгээ өгөхдөө доор дурдсан шалгууруудын тест болон Компьютер дээр ажиллах чадвараар 30 хүртэл оноог өгнө.

- Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
- Дүн шинжилгээ хийх чадвар;
- Асуудал шийдвэрлэх чадвар;
- Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
- Багаар ажиллах чадвар;
- Компьютерийн хэрэглээ, чадвар

4.7. Мэдлэг, боловсролын түвшин, төрийн албаны мэргэшил, туршлага, мэргэжил, ур чадварын нийлбэр оноогоор хамгийн өндөр оноо авсан 1-2 оролцогчийг дараагийн шатны ярилцлагад оролцуулна.

4.8. Ярилцлага хийхдээ оролцогчоос түүний ажлын байрны чиг үүрэг, онцлог, мэргэжил, ур чадвартай холбогдсон асуулт асууж 20 хүртэл оноо өгнө.

4.9. Сонгон шалгаруулалтын оноо, үнэлгээг энэ журмын хавсралтаар батлагдсан "Дүнгийн хуудас"-аар нэгтгэн оролцогчдод танилцуулна.



“Багануур Үйлдвэрлэл технологийн парк”  
ОНӨТҮГ-ийн даргын 2023 оны 06 сарын 19-ний  
өдрийн А/08 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

№	Оролцогчийн овог нэр	Мэдлэг, боловсролын түвшний оноо	төрийн албаны мэргэшил, туршлагын оноо	мэргэжил, ур чадварын оноо	Ярилцлагын оноо	Нийт оноо
1						
2						
3						

Жич: Оролцогчдын нэрийг нийт онооны дарааллаар эрэмбэлнэ.

	Нэр		гарын үсэг
Ажлын хэсэг:	-----	/	/
	-----	/	/
	-----	/	/

20.....оны .... сарын .... ны өдөр